

**ЗҮҮНБАЯН-УЛААН СУМЫН ЗАСАГ ДАРГЫН ТАМГЫН ГАЗРЫН АВЛИГЫН ЭСРЭГ  
ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ 2024 ОНЫ ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ БИЕЛЭЛТ**

2024.12.06

Баян-Улаан

Хэрэгжүүлэх арга хэмжээ	Гүйцэтгэлийн шалгуур үзүүлэлт	Суурь түвшин	Хүрэх түвшин	Төсөв	Хугацаа	Хэрэгжилт
1	2	3	4	5	6	7
<b>Зорилт Нэг. Авлигын эсрэг хууль тогтоомжийг иргэдэд сурталчлах, соён гэгээрүүлэх үйл ажиллагааны хүртээмжийг нэмэгдүүлэх.</b>						
1.1. Авлигатай тэмцэх газраас бэлтгэсэн шторк, инфографик, нийтлэл, зурагт хуудас, цахим ном, гарын авлага зэргийг тухайн орон нутгийн хэвлэл мэдээллийн хэрэгсэл, албан ёсны цахим хуудас болон нийгмийн сүлжээ (фэйсбүүк, твиттер, инстаграм youtube суваг), мөн лед дэлгэц, сурталчилгааны самбарт байршуулах зэрэг бүхий л боломжтой хэлбэрээр олон нийтэд хүргэх.	Түгээсэн мэдээлэл, иргэдийн хандалтын тоо, Харьяа газар нэгжийг хамруулсан тоо	Хандалтын тоо 400.000 иргэн	500,000 иргэнээс доошгүй	400,000	1-4 дүгээр улирал	Авлигатай тэмцэх газраас ирсэн болон өөрсдийн бэлтгэсэн 34 төрлийн аудио зөвлөгөө, 14 төрлийн шторк, 25 төрлийн гарын авлагыг сумын цахим хуудас, фэйсбүүк хаяг, мэдээллийн самбар зэрэгт байршуулан иргэдэд ил тод мэдээллэсэн. Мөн нээлттэй хаалганы өдөрлөгөөр аудио зөвлөгөө, шторкыг дэлгэцээр гарган иргэдэд хүргэж 300 гаруй гарын авлага бэлтгэн тараасан. Цахимаар 450 гаруй хандалт авсан. Хөтөлбөр хэрэгжүүлэх сургалтын зардлаас бичиг хэргийн зардал, тараах материал хэвлэх, сурталчилгаа зохион байгуулхад 400,000 төгрөг зарцуулсан.
1.2. Авлигын эсрэг нөлөөллийн арга хэмжээг нутаг дэвсгэрийн нэгж, байгууллага, салбарын онцлогт тохируулан зохион байгуулах.	Нөлөөллийн арга хэмжээ зохион байгуулсан тоо	1 ажил, арга хэмжээ зохион байгуулсан	Нөлөөллийн 2 ажил арга хэмжээ зохион байгуулах	-	1-4 дүгээр улирал	Албан байгууллага, аж ахуйн нэгж, иргэдийн дунд "Шүгэл үлээх ажиллагаа", "Шүүр ажиллагаа"-ны хүрээнд сургалт зохион байгуулж 20 иргэдийн дунд нээлттэй ярилцлага хийсэн. "Авлигын эсрэг нэгдье" 1 сарын аяны хүрээнд мэдээлэл хийн гадаа мэдээллийн талбайд 3 ширхэш аннас хийн ил тодоор байршуулж 200,000 төгрөг зарцуулсан.
1.3. Авлигын эсрэг үйл ажиллагааг мэдээлэн сурталчлах мэдээллийн самбар ажиллуулах, иргэдээс мэдээлэл авах суурин утасны тоо нэмэгдүүлэх.	Шинэчилсэн мэдээллийн тоогоор	-	Сар бүр шинэчлэх	-	1-4 дүгээр улирал	Авлигын эсрэг үйл ажиллагааг сурталчилах мэдээллийн самбар Засаг даргын Тамгын газарт 2 ширхэг, Эрүүл мэндийн төв, Ерөнхий боловсролийн сургууль, Соёлын төв, Хүүхдийн цэцэрлэгт тус бүр 1 ширхэг мэдээллийн самбар байршуулан тухай бүр шинэчлэн ажиллаж байна. Суурин утас ЗДТГ-3 ширхэг, ЭМТ-1 ширхэг, Соёлын төв-1 ширхэг, СӨББ-1 ширхэг,




						ЕБС-2 ширхэгийг байршуулан иргэдийн санал хүсэлтийг тухай бүр авч шийдвэр гаргах түвшинд саналыг тусган хэрэгжүүлж байна.
1.4. Өөрсдийн үйл ажиллагааг авлигын эрсдэлээс ангид байхад чиглэсэн, ёс зүй, шударга байдлыг уриалсан агуулга бүхий (шторк, зурагт хуудас, сонины нийтлэл, радио контент, цахим, хэвлэмэл ном, гарын авлага, броюшур зэргээс боломжит хэлбэрийг сонгон) сурталчилгааг хийж олон нийтэд хүргэсэн байх.	Боловсруулсан материал, бэлтгэсэн нийтлэл нэвтрүүлгийн тоо	600 ш тараах материал	2 доошгүй сурталчилгааны материал боловсруулах 2 доошгүй нэвтрүүлэг, контент бэлтгэн цацах	200,000	1,3 дугаар улирал	Өөрсдийн үйл ажиллагааг авлигаас ангид байх чиглэлээр сумын цахим хуудас, вэйб сайт, фэйсбүүк, цахим орчинд байршуулсан. Мөн авлига, ашиг сонирхол, шударга байдал зэргээр 500 гарын авлага боршур хийн нээлттэй хаалганы өдөрлөг болон багийн иргэдийн нийтийн хурлуудад мэдээлэл хийн тараасан. Хад, Дэвшил, Цахиурт, Эмгэд багийн хурлуудад авлига ашиг сонирхолын зөрчлөөс уридчилан сэргийлэх талаар сурталчилгаа зохион байгуулж 366 малчид иргэд хамрагдаж 200,000 төгрөг зарцуулсан.
<b>Зорилт 2. Авлигын эсрэг сургалт зохион байгуулах, сургалтад хамруулах</b>						
2.1. Төрийн албанд шинээр томилогдсон албан хаагчдыг авлигын эсрэг сургалтад хамруулсан байх	Сургалтад хамрагдсан албан хаагчийн тоо	1	Шинэ томилогдсон албан хаагчдыг	-	Тухай бүр	Төрийн албанд шинээр томилогдсон болон авлига ашиг сонирхолын мэдүүлэг гаргагч 14 төрийн албан хаагчдад 2 удаа сургалт зохион байгуулсан. 2024 онд төрийн албаны шалгалтанд тэнцэн ажилд томилогдсон 2 албан хаагчдад авлигаас ангид байх талаар зөвлөгөө өгч, гүйцэтгэлийн төлөвлөгөөнд заалт болгон оруулж танилцуулсан.
2.2. Тухайн байгууллагын хариуцдаг, шууд хамаардаг, хамтран ажилладаг (тухайлбал, тусгай зөвшөөрөл эзэмшигч, итгэмжлэгдсэн төлөөлөгч, хамтран ажилладаг бизнесийн байгууллага, үйлчилгээ авдаг хуулийн этгээд, иргэн, хяналт, оролцоо хэрэгжүүлдэг ТББ г.м) байгууллагад авлигаас урьдчилан сэргийлэх, ил тод байдлыг сайжруулах, ёс зүйг дээшлүүлэх, үйл ажиллагааны хүнд суртлыг бууруулах чиглэлээр авч хэрэгжүүлж байгаа арга хэмжээ, түүний	Хамтран ажилласан байгууллага, арга хэмжээний тоо	-	1 доошгүй арга хэмжээ зохион байгуулах	-	1-3 дугаар улирал	Тус суманд үйл ажиллагаа явуулж байгаа 42 Аж ахуйн нэгж, хоршоо, төрийн бус байгууллагын авлигаас урьдчилан сэргийлэх, хүнд сурталгүй байх зэрэгт хяналт тавин ил тод нээлттэй байдлыг сайжруулан мэдээллийн самбар байршуулж тухай бүр шинэчлэн ажиллаж байна.

үр дүнг мэдээлэх сурталчлах арга хэмжээг зохион байгуулах.						
Зорилт 3. Авлигын эсрэг үйл ажиллагаанд олон нийтийн хяналтыг бий болгох						
3.1. Төрийн байгууллага, хувийн хэвшлийн хооронд байгуулах аливаа гэрээ хэлэлцээрт авлигаас урьдчилан сэргийлэх асуудлыг тусгах талаар зохион байгуулалтын арга хэмжээ авсан байх.	Авлигаас урьдчилан сэргийлэх заалт тусгасан гэрээний тоо	1 төрлийн гэрээнд	4 доошгүй гэрээнд тусгасан байна	-	1-4 дүгээр улирал	ОНХСангийн хөрөнгөөр 4 ажлыг харьцуулалтын аргаар зарлаж бараа худалдан авах ажиллагааны журмын дагуу шалгаруулах үнэлгээний хорооны гишүүдээс ашиг сонирхолын зөрчилтэй эсэх асуудлыг бөглүүлэн авч хавсаргадаг. Шалгарсан байгууллага, хувийн хэвшлийн, аж ахуй нэгж байгууллагатай хийх гэрээнд авлигаас урьдчилан сэргийлэх, авлигаас ангид байх талаар заалт оруулж хэрэгжүүлэн ажиллаж байна.
3.2. Төрийн байгууллага, албан тушаалтны үйл ажиллагаанд олон нийтийн хяналтыг хэрэгжүүлэх журам"-ыг хэрэгжүүлэх.	Олон нийтийн хяналт хэрэгжүүлсэн үйл ажиллагаа, байгууллагын тоо	-	1 үйл ажиллагаа, 5 байгууллага	(Орон нутгийн төсөв)	2,3 дугаар улирал	Орон нутгийн хөгжлийн сангийн хөрөнгөөр хийж байгаа бүтээн байгуулалтын ажлуудад Иргэдийн төлөөлөгчдын хурал, Засаг даргын Тамгын газрын ажлын хэсэг төрийн бус байгууллагын гишүүдийг оролцуулсан хөндлөнгийн хяналт шалгалтыг тухай бүр хийж авлига ашиг сонирхолын зөрчил гаргахгүй байх, хувийн ашиг сонирхолд нийцүүлэн үйл ажиллагаа явуулахгүй байх талаар анхааруулж зөвлөгөө өгөн ажиллаж байна.
Зорилт 4. Авлига, ашиг сонирхолын зөрчил үүсгэх шалтгаан, нөхцөлийг арилгуулах арга хэмжээ авах.						
4.1. Авлигын эрсдэл ба авлига гарах боломжийг бууруулах чиглэлээр холбогдох арга хэмжээг авч хэрэгжүүлэх (үйлчилгээг цахимжуулах, шат дамжлага бууруулах, ил тод байдлыг нэмэгдүүлэх, гомдол мэдээлэлд дүн шинжилгээ хийж, асуудлыг шийдвэрлүүлэх, эрсдэлийн үнэлгээ хийлгэх г.м/	Цахимжуулсан үйлжилгээ, зохион байгуулсан арга хэмжээний тоо	-	-	-	1-4 улирал	Авлигын гэмт хэрэгтэй холбогдолтой санал гомдол иргэдээс гараагүй. Авлигад өртөж болзошгүй албан тушаалтнуудын нэрсийн жагсаалтыг гаргаж ил тодын самбарт байршуулсан.
4.2. Сумын хэмжээнд авлигаас урьдчилан сэргийлэх, эрсдэлийг тодорхойлох, хүнд суртлыг бууруулах чиглэлээр уулзалт зохион байгуулах.	уулзалт зохион байгуулсан тоо	-	1 удаа уулзалт зохион байгуулсан байна	-	2-3 дугаар улирал	Сумын хэмжээнд авлигын эсрэг нэгдье 1 сарын аяны хүрээнд ажилтан албан хаагчдад авлигаас урьдчилан сэргийлэх, авлигагүй төрийн албан хаагч чиглэлээр 1 удаа уулзалт зохион байгуулж 42 албан хаагч хамрагдсан. Төрийн албан хаагчид иргэдэд төрийн үйлчилгээг хөнгөн шуурхай, чирэгдэлгүй, хүнд сурталгүй үзүүлж

						байна.
<b>Зорилт 5. Байгууллагын удирдлагын авлигатай тэмцэх хүсэл эрмэлзэл, санаачилга өрнүүлэх</b>						
5.1. Удирдлагын зүгээс 2024 оны авлигын эсрэг үйл ажиллагааны төлөвлөгөөг 2024 оны 1-р улиралд, хэрэгжилтийн явцыг эхний хагас жилд, хэрэгжилт, хүрсэн үр дүнг жилийн эцсээр нийт албан хаагчдадаа танилцуулах.	Төлөвлөгөө болон тайлан боловсруулж, танилцуулснаар	АТҮХ, Авлигын эсрэг байгууллагын төлөвлөгөө, тайлан	Нийт алба хаагчдад танилцуулсан байна	-	1-4 дүгээр улирал	Авлигатай тэмцэх үндэсний хөтөлбөрийг хэрэгжүүлэх ажлын төлөвлөгөөг жил бүр гарган хэрэгжилтийг тооцон ажиллаж байна. Сумын авлига, ашиг сонирхлын зөрчлийн эсрэг үйл ажиллагааны төлөвлөгөөг 2024 оны 3 сарын 10-нд сумын Иргэдийн төлөөлөгчдийн хурлын зөвлөлийн хуралд танилцуулан батлуулан мөрдөн ажиллаж байгаа бөгөөд биелэлт, авлигатай тэмцэх газраас ирсэн албан бичиг, зөвлөмжүүдийг тухай бүр бүх төрийн албан хаагчдад танилцуулан хэвшсэн.
5.2. Авлигатай тэмцэх газраас ирүүлсэн дүрэм журам, ёс зүйн дүрмийн төсөлд өгсөн санал, зөвлөмжийг тусган, хэрэгжүүлэх.	Хэрэгжүүлсэн арга хэмжээ	-	Тухай бүр	-	1-4 дүгээр улирал	Авлигатай тэмцэх газраас ирүүлсэн дүрэм журам, албан бичиг, аймгийн Засаг даргын албан бичиг зэргийг тухай бүр хэрэгжүүлэн албан байгууллагын дарга, эрхлэгч нарт хүргүүлэн ажиллаж байна.
<b>Зорилт 6. Удирдлага салбар, нэгж, байгууллагын хүрээнд авлигаас урьдчилан сэргийлэх, соён гэгээрүүлэх чиглэлээр санаачлан хийх ажил, арга хэмжээг нэмж төлөвлөн, тайлагнах.</b>						
6.1. Авлигын хор хөнөөлийн талаар албан байгууллагын удирдах албан тушаалтан, албан хаагчдад соён гэгээрүүлэх үйл ажиллагааг зохион байгуулах.	Зохион байгуулсан сургалтын тоо	30	40 доошгүй удирдах албан тушаалтан, албан хаагчдад сургалт зохион байгуулсан байна.	-	1 дүгээр улирал	Авлигаас ангид байх, түүний хор уршгийн талаар богино хэмжээний кино, шторк болон сурталчилгааны бусад хэлбэрээр албан байгууллагын дарга, эрхлэгч ажилан албан хаагчдад хүргэх ажлыг тогтмолжуулан соён гэгээрүүлэх сэтгэлгээ, хандлагад өөрчлөлт оруулах ажлыг хүртээмжтэй байлгах хэлбэрээр сургалт зохион байгуулж 51 төрийн албан хаагч хамрагдсан.
6.2. Авлига, ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх чиглэлээр хууль тогтоомжид заасан хориглолт хязгаарлалт зөрчсөн томилгоо, хувийн ашиг сонирхлын урьдчилсан мэдүүлэг, хөрөнгө, орлогын мэдүүлгийн хугацаанд хяналт, шалгалт явуулах.	Хяналт шалгалтын тоогоор	1	1 удаа зохион байгуулсан байна.	-	4 дүгээр улирал	Төрийн албанд шинээр томилогдож ажиллах төрийн албан хаагч болон төсөвт байгууллагын дарга, эрхлэгч нарын хувийн ашиг сонирхлын урьчилсан мэдүүлгийг гаргаж авлигатай тэмцэх газарт хүргүүлэн хянуулсаны үндсэн дээр албан тушаалд томилон ажиллуулж байна. Хууль бус журам зөрчиж томилсон төрийн албан хаагч болон

3.8.2. Орон нутгийн төсвийн төсөлд санал авах хэлэлцүүлгийн талаар Засгийн газрын www.iltod.mn, www.shilendans.com цахим хуудас болон бусад мэдээллийн хэрэгслээр иргэд, олон нийтэд мэдээлэл хүргэх.	Тухай бүр	-	-	-	Төсвийн төсөл болон иргэдийн саналыг сумын вэб сайтад жил бүр мэдээлж байна. Мөн сумын төсвийн төслийн нэгтгэлийг бүтэн жилээр гарган шилэн дансанд байршуулж хэвшсэн.	100
Худалдан авах ажиллагааны төлөвлөгөөг байршуулах	Тухай бүр	-	-	-	Худалдан авах ажиллагааны төлөвлөгөөг 1 дүгээр сарын 10-ны дотор шилэн данс байршуулж tender.gov.mn сайт болон сумын вэб сайтад байршуулсан.	100
Худалдан авсан бараа, ажил үйлчилгээний тайланг байршуулах (хагас, бүтэн жил)	Тухай бүр	-	-	-	Худалдан авах ажиллагааны тайланг хагас бүтэн жилээр ХОХБХ-т маягтын дагуу явуулж байна. Мөн шилэн данс болон ОНХсангийн ЗГУМС-д тайланг шивж оруулж байна.	100
3.11.1.Төрийн байгууллага, түүний удирдлагын үйл ажиллагаанд төрийн бус байгууллага хяналт тавих боломжийг бүрдүүлж, төрийн зарим чиг үүргийг төрийн бус байгууллагаар гүйцэтгүүлж, төсвөөс олгож байгаа санхүүжилтийн зарцуулалтыг ил тод, нээлттэй болгож нийтэд мэдээлэх.	Тухай бүр	-	-	-	Төсвөөс олгож байгаа санхүүжилтийн зардлыг шилэн дансанд тухай бүр тогтмол оруулж мэдээллийн самбарт ил тодоор байршуулан ажиллаж байна. Орон нутгийн хөгжлийн сангийн үйл ажиллагаанд тогтмол хяналт тавин ажиллаж байна.	100
Хэрэгжилтийн хувь: 95%						
Нийт хувь: 93.5%						

БИЕЛЭЛТ ГАРГАСАН:

ТАМГЫН ГАЗРЫН ДАРГА  Б.ШАГДАРСҮРЭН  
 АРХИВ, БИЧИГ ХЭРГИЙН ЭРХЛЭГЧ  Н.ДАВААСҮРЭН  
 ХЯНАСАН  
 ЗАСАГ ДАРГА  Х.БАДЖИННЯМ

